

МОНГОЛЫН “ХУЛЖ” ГЭДЭГ
ГАЗАР УСНЫ НЭРИЙН ГАРЛЫГ МӨШГӨХҮЙ¹

Ю.Мөнх-Амгалан, Андрей Шимүнек

Түлхүүр үг: *Нэр зүй, газар усны нэр, түүхэн харьцуулсан хэл шинжлэл, Хятаны хаант улс (МЭ 907-1125 он), хятан буюу кидан хэл, 阿保機 Абаозци, 安巴堅 Аньбацзянь, Орду Балык (Ordu Baliq) буюу Хар балгас*

Монгол домог зүйн сангаас нэхэн сонирхож үзвэл *хулж*, *хулжих*, *хулжаах* зэрэг үгтэй холбогдсон “Хулжийн бүрд”, “Хөрвөхийн бүрд” хэмээх нэгэн сонин домог байдаг. Уг домгийг бүрэн эхээр нь доор сийрүүлэе. Үүнд:

“Хэнтий аймгийн Дархан сумын төвөөс зүүн хойш 30 орчим км зайтай газарт сайн чанарын амны хужир бүхий зэгст нуур байдгийг Хулжийн бүрд, түүнээс зүүн урагш 40-өөд км зайтай орших Язаарын уулын баруухан доор байх бас нэг бүрдийг Хөрвөхийн бүрд гэдэг. Энэ хоёр бүрдийн тухай нутгийнхан сонин домог хүүрнэдэг.

Эрт цагт Чингис хаан аян дайнд явж байхдаа Хулжийн бүрдийн дэргэд бууж түр саатаад явахын өмнө унаагаа юүлэх болж нэг сайн морь барихыг агтчиндаа даалгажээ. Агтчин нь их хааны хааяа нэг унадаг загал морийг нь барих гэтэл хур хүчтэй тэр морь нь олон адууны дундаас цойлон гарч, улмаар түүнийг хулжааж орхижээ. Агтчин араас нь нэхэн хөөж нэгэн тойромд хөрвөөж байхад нь барьж авчээ. Тэр цагаас загал морийг хулжсан газрыг морь хулжаасан газар хэмээн Хулжаахын бүрд, хөрвөөсөн газрыг Хөрвөөхийн бүрд гэж нэрлэх болсон гэнэ.

Олон зууны урсгалд Хулжаахын бүрд нь Хулжихын бүрд болоод одоо Хулжийн бүрд, Хөрвөөхийн бүрд нь Хөрвөхийн бүрд болсон гэж нутгийнхан хэлэлцсээр иржээ” (Домог, 2014:322).

Домог ийн өгүүлэх бөгөөтөл энэхүү домгоос үүдэн энд өгүүлэгдэх “хулж” хэмээх үгийг бид илүүтэй сонирхон энэ нь эрт үеэс монгол орны хангай, говийн нутгаар иргэншин сууж төр улсаа байгуулж байсан хятанчуудын хэлний *qulji (qu.ulji) [036.177] гэдэг үгтэй ямар нэгэн байдлаар холбоотой юм биш байгаа гэсэн таамаглал төрснөөр эл бэсрэг өгүүллийг бэлдэхэд хүрсэн билээ. Ингээд “хулж” хэмээх үг оролцсон монгол газар усны нэрийг зэрвэсхэн хайж үзвэл Хэнтий, Булган, Дундговь аймгийн зарим сумын нутгаас цөөн хэдэн газар усны нэрийн зүйл олдлоо. Тухайлбал, Хэнтий аймгийн Баянмөнх сумын

¹ Энэхүү өгүүлэлд холбогдох зарим ном хэрэглэгдэхүүнийг олж өгч тусалсан МУИС-ийн докторант Майлууугийн Отгонбаярт талархсанаа илэрхийлэе.

нутагт Хулжийн хоолой, Хулжийн бүрд², Булган аймгийн нутагт Хулж гол³, Хулж хөндий⁴, Хулжийн халуун рашаан⁵, Сайхан хульжийн рашаан⁶, Дундговь аймгийн нутагт Хулжийн зоо⁷ гэх зэргийн уул усны нэр тэмдэглэгдэн өдгөө хүртэл хэрэглэгдсээр байна. Тэрчлэн “Монголын үндэсний нэвтэрхий толь”-д бас энэ үг тэмдэглэгджээ⁸.

“Хулж” хэмээх газар усны нэр тэмдэглэгдсэн эдгээр аймгийн дурдсан сумдын нутаг нь хятан нартай ямар холбоотой байж болохыг цааш лавлахад археологич, түүхч эрдэмтдийн бичсэнээр бол Хятан улс монгол нутгийг 924 онд эзэлсэн байна (Виттфогел ба Фэн, 1946:576)⁹. Тухайлбал, 14-р зууны үед амьдарч байсан монгол түшмэл Тогтоогийн эмхэтгэсэн 遼史 *Ляо Ши* буюу *Ляо улсын түүхэн судар*-т дараах баримт байна. Үүнд:

三年...次古回鶻城勒石紀功...詔礪闕遏可汗故碑以契丹突厥漢字紀其功 (*Ляо Ши*. 2-р бүлэг, 19-20 дахь тал).

Энэ өгүүлбэрийг монголчилбол:

“Гурван онд¹⁰ [Хятаны хаан] хуучин уйгар хотод очиж өөрийнхөө алдар гавьяаг чулуун дээр сийлүүлэв... Билгэ хааны хуучин хөшөөний бичээсийг арилгахыг тушааж, уг бичээсийн оронд өөрийнхөө алдар гавьяаг хятан, түрэг, хятад [гурван хэлээр] сийлүүлэхээр зарлиг буулгав”.

Хятаны хааны сийлүүлэхээр тушаасан энэхүү гурван хэлний бичээс одоо хэр хараахан олдоогүй байгаа хэдий ч *Ляо улсын түүхэн судар*-т ийнхүү тодорхой бичсэн нь хятанчууд монгол нутгийг 924 онд эзэлснийг баттай гэрчилж байна. Хятанчууд “Монгол нутгийг эзлэн авснаар Хэрлэн мөрнөөр савлан Туул, Орхоны сав хүртэлх нутагт, дорно зүгт Шар тэнгист тулталх нутагтай байжээ. Өмнө талдаа Хятадын хойд ба зүүн тал хүрч байжээ”¹¹.

² Эл бяцхан өгүүлийг хамтран тэрлэгчийн нэгэн бээр чухамхүү энэ л нутагт төрсөн бөгөөд түүний лавтайяа дээд хэдэн үе нь мөн энэхүү газар нутаг, орон зайд дөрвөн цагийн эргэлтэд нутаглан амьдарч байсан бөлгөө.

³ “Булган аймгийн Могодын нурууны баруунаас эх авч Орхон голд цутгадаг. Урт 40 км. Өөр нэг Хулж гол Булганы Сайхан сумын Олон булгаас эх авч Хануй голд цутгадаг” (Чадраа, 2009:1697а). “Булган аймгийн нутагт Могод сумын төвийн хойд нураанаас (Жаргалант уулаас) эх авч зүүн хойш урсаад Орхонд нийлэх жижиг гол. Энд Могод сумын төв дээр сульфат натрийн төрөлд багтах халуун рашаан бий” (Шагдар, 2000:302б).

⁴ “Булган аймгийн Сайхан сумын баруун хэсэгт оршдог. Ойт хээр, хээрийн ургамалтай” (Чадраа, 2009:1697а). Хулж хөндийг зарим эх сурвалжид Хулжийн хөндий гээд “Булган аймгийн Сайхан-Овоо уулын баруун доогуур үргэлжилсэн уудам хөндий” (Шагдар, 2000:302б) гэжээ.

⁵ “Булган аймгийн Могод сумын нутагт оршдог, сульфат карбонат хлорид натри кальцийн найрлагатай, хүхэр устөрөгч хийтэй. Мэдрэл, бөөр, хэрх, арьсны гм өвчин анагаах чанартай” (Чадраа, 2009:1697а). Хулжийн халуун рашааныг зарим эх сурвалжид Хульжийн рашаан гээд “Могод сумын төв дээр Сайхан хульжийн рашааны зүүн талд ойрхон орших сульфат натрийн найрлагатай нуур рашаан” (Шагдар, 2000:303а) гэсэн байна.

⁶ “Булган аймгийн Могод сумын төвд далайн төвшнөөс дээш 1500 м өндөр оршдог халуун рашаан юм. Сульфат натрийн рашааны төрөлд багтана. Бусад халуун рашаанаас найрлага үүслийн хувьд ялгаатай онцлог рашаан юм. Бөөр, нуруу, хэрх өвчин, арьс өнгөний өвчнийг анагаахад сайн” (Шагдар, 2000:195).

⁷ “Дундговь аймгийн Өлзийт сумын өмнө захад Модон овоогийн говийн баруун өмнө оршдог, 1250 м өндөр” (Чадраа, 2009:1697а).

⁸ 2009 онд гурван ботиор хэвлэгдсэн “Монголын үндэсний нэвтэрхий толь”-д 1851 онд Хаант Орос, Манж Чин улсын хооронд байгуулсан “Хулжийн гэрээ” гэсэн толгой үг байна. Энэ нь Хулж гэдэг газар юм уу, эсвэл ийм нэртэй хотод гэрээ байгуулсан юм уу гэдгийг бид магадлах болно. Мөн Хятадын Шинжаан-Уйгурын өөртөө засах оронд Или мөрний эрэгт оршдог Хулж гэсэн хот байна. Энэ хотын нэрийг чухам монгол бичгээр *qulji* гэж бичдэг эсэх нь түүхэн хэл шинжлэлийн үүднээс бидэнд тодорхойгүй байгаа тул энэ үгийг бидний энд сонирхож байгаа үгтэй шууд холбож үзэх аргагүй байна. Энэ хоёр үгийн талаар дараах толь бичигт үзмүү: (Чадраа, 2009:1697а).

⁹ Х.Пэрлээгийн бичсэнээр бол “Хятан улс Монгол орныг 923 онд эзэлж, Кыргыз улсын ноёрхлыг унагасан байна” (Пэрлээ, 1959а:76). Үнэн хэрэг дээрээ Хятан улс Монгол нутгийг 923 онд биш харин 924 онд эзэлсэн (Виттфогел ба Фэн, 1946:576) бөгөөд үүнээс гадна тухайн үед кыргызууд буюу хиргисүүд Монголд байгаагүй, харин Енисей дэх нутагтаа байсан юм байна. Кыргызууд 840 онд Монгол нутагт уулгалан орж ирээд уйгуруудын хаант улсын нийслэл Орду Балык (Ordu Baliq) буюу одоогийн Харбалгас гэдэг хотыг эзэлсэн хэрнээ Монгол нутагт төдийлэн удаан суурьшилгүй (Beckwith, Christopher, 2009:158-159) Енисей дэх нутаг руугаа буцсан бололтой юм.

¹⁰ МЭ 924 он

¹¹ Б.Балжиннямын бичсэнээр бол “923 онд Хиданы хаан Амбаган цэрэглэн одоогийн Монгол нутгийг эзлэн авснаар Хэрлэн мөрнөөр савлан Туул, Орхоны сав хүртэлх нутагт, дорно зүгт Шар тэнгист тулталх нутагтай байжээ. Өмнө талдаа Хятадын хойд ба зүүн тал хүрч байжээ” (Балжинням, 2012: 247). Хятадын түүхэн судраас үзвэл 923 онд биш харин 924 онд Хятаны хаан 阿保機 Абаозци буюу 安巴堅 Аньбацзянь Монгол нутагт орж ирээд Билгэ хааны хуучин хөшөөний бичээсийг арилгахыг тушааж, уг бичээсийн оронд өөрийнхөө алдар гавьяаг

Хятан хэлээр ярьдаг хүмүүс “Хулж” хэмээх газар усны нэр бүхий дээр дурдсан нутаг оронд амьдарч байсны өөр нэгэн бодитой гэрч бол зөвхөн Хэнтий, Булган аймгийн газар нутгаас л хятан үсгээр тэмдэглэсэн бичгийн дурсгал олдсон явдал юм (Пэрлээ, 1959а; 1959б; 1978; Шимүнек 2011:105b; 2017:209, п.56). Хятан бичээсүүд Монгол улсын Булган болон Хэнтий аймгийн хэд хэдэн сумаас олдсон байдаг. Тухайлбал, Булган аймгийн Дашинчилэн сумын Чинтолгойн балгасны бичээс (Пэрлээ, 1978:15-17), Булган аймгийн Дашинчилэн сумын Харбуухын балгасны дээврийн вааран дээрх дүрс бичээс (*Ibid.*, 19-20), Хэнтий аймгийн Мөрөн сумын Эрдэнэ-Овоо уулын хадны бичээс (*Ibid.*, 21-22), Хэнтий аймгийн Мөрөн сумын Салбарын уулын Бичигт Ханан хадан дээрх бичээс (*Ibid.*, 17-19), Хэнтий аймгийн Батширээт сумын Биндэр уулын Рашаан хадны бичээс (*Ibid.*, 20-21) зэрэг хятан хэлний цувраа үсгээр¹² бичсэн бичээсүүдийг энд дурдаж болно.

Хэнтий, Булган, Дундговь аймгийн тодорхой нутагт “Хулж” нэртэй газар усны нэр тэмдэглэгдсэн хийгээд чухамхүү Хэнтий, Булган аймгийн энэ нутаг орноос хятанчуудын хот балгас, цэргийн хуаран, бэхлэлт хэрэмний үлдэгдэл болон хятан хэлний бичгийн дурсгалууд олдсон зэрэг эдгээр хөдөлшгүй түүхэн баримтуудыг холбон хийсвэрлэж үзвэл эх нутгаасаа алслан одож умрын Монгол нутагт томилогдон ирж түр суурьшсан хятан цэрэг, албат ардууд нутаг орноо санагалзахын учир хятан хэлнийхээ газар усны ерөнхий дэвсгэр нэр болох “Хулж” гэдэг нэрийг Монгол орны дээр дурдсан газар уснаа оноон өгсөн байж болох юм.

Австралийн эрдэмтэн, хятан хэл судлаач Дэниэл Кэйн (Daniel Kane)-ий судалгааны үр дүнгээс үзвэл, тэрээр хятан бүлэглэмэл үсгээр¹³ бичсэн [036.177] хэмээх үгийг Ляо улсын нэрийн Ляо (遼) гэдгийг илэрхийлдэг бөгөөд энэ үгэнд тохиолддог [177] үсгийг *ulji* гэж уншвал зүйтэй гэж үзсэн байна (Kane 2013). Харин Итали улсын Наполи хотын Дорно дахины их сургуулийн монгол судлалын профессор Андрей Шимүнек (Andrew Shimunek)-ийн судалгаагаар [036.177] үгийг *qu.ulji* хэмээн тайлж уншжээ (Шимүнек, 2017:201).

Хятан хэлний энэхүү үг нь хятан бүлэглэмэл үсгийн хэд хэдэн бичээст тохиолддог. Жишээлбэл, 1101 оны *Даоцзун хуанди айцэ* 道宗皇帝哀冊 бичээсийн титэм бичээс (хятад. 蓋 盖, англи. *canoru*) болон 1092 оны *Елюй Диле мучжисмин* 耶律迪烈墓誌銘 бичээсийн доор дурдсан өгүүлбэрт тус тус тохиолдож байна¹⁴.

[373]	[119.097.144]	[036.177]	[365.144.339]
<их>	<dau.ur.°ñ>	<qu.ulji>	<q1ta.°ñ.i>
их	дундад (?)	Ляо	хятан ^{GEN}

Их Дундад (?) Ляо Хятаны... (*Даоцзун хуанди айцэ*, титэм бичээс, 1-6).

[373]	[247.362.249]	[036.177]	[365.339]	[334.097.140]
<их>	<t.iau.rdu>	<qu.ulji>	<q1ta.i>	<g.ur.en>
их	төв (?)	Ляо	хятан ^{GEN}	улс ^{GEN}

Их Төв (?) Ляо Хятаны Улсын... (*Елюй Диле мучжисмин*, 1: 1-5).

хятан, түрэг, хятад [гурван хэлээр] сийлүүлэх зарлиг буулгасан байна (Виттфогел ба Фэн, 1946:576). Австрали улсын эрдэмтэн, хятан хэл судлаач Дэниэл Кэйн таамагласнаар бол хятан хэлний дурсгалуудад тохиолддог [311.334.222] хэмээх үг нь Хятаны хаант улсын анхны хаан 安巴堅 Аньбацзянь буюу 阿保機 Абаозцигийн уугуул хятан хэлний нэр бололтой (Кэйн, 2009:129). Бидний сэргээснээр энэ нэрийг <b.g.ñ> хэмээн галиглууштай бөгөөд авиан зүйн хэлбэрийг нь *(a)b(V)g(V)ñ гэж сэргээвэл зохистой болно.

¹² Цувраа үсэг буюу англиар *linear script* хэмээх энэ нэр томъёог АНУ-ын Индиана их сургуулийн монгол судлалын профессор Хар Дорж багш зохиосон юм (Kara, 1977, 1987, 2005). Шимүнек (2017:210, п.58)-ийг бас үзмүү.

¹³ Бүлэглэмэл үсэг буюу англиар *assembled script* хэмээх энэ нэр томъёог мөн профессор Хар Дорж багш зохиосон (Kara, 1977, 1987, 2005). Шимүнек (2017:210, п.58)-ийг бас үзмүү.

¹⁴ Энэ хоёр бичээсийг БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн профессор Чингэлтэй багшийн эмхэтгэж хуулбарласан зураг бүхий номоос үзэв (2002). Тайлбар, бүтээврийн тайлц, орчуулга, авиан зүйн сэргээсэн хэлбэр сэлтийг Шимүнекийн номоос шууд авч энд монголчлон оруулсан болно (2017).

Эндээс үзвэл хятан хэлний энэхүү *qulji <qu.ulji> [036.177] гэдэг үг авиан зүйн хэлбэрийн хувьд Хэнтий болон Булган аймгийн нутагт тэмдэглэгдсэн “Хулж” хэмээх газар усны нэртэй яг тохирч байна. Хэл шинжлэлийн чухал учир холбогдол бүхий эл баримтыг Х.Пэрлээгийн археологийн судалгааны үр дүнтэй зэрэгцүүлж үзвэл энэ хоёр үг нь нэгэн ижил үг байх магадлал хүрэлцээтэй их байгаа юм. Иймд Хэнтий, Булган болон Дундговь аймгийн зарим нутагт байдаг, дээр дурдсан “Хулж” гэдэг үг бүхий газар усны ихэнх нэр нь угаасаа хятан нарын соёлын өвийн үлдэгдэл мөн хэмээн хэл шинжлэл, түүх, археологийн судалгааны үр дүнд тулгуурлан хэлэх хөдөлшгүй үндэслэлтэй гэж үзэж байна.

Товчилсон үгийн жагсаалт

GEN	англиар <i>genitive</i> буюу монголоор харьяалахын тийн ялгал
<i>Ibid.</i>	латин хэлний <i>ibidem</i> буюу монголоор “мөн тэнд”
n.	зүүлт буюу англиар <i>footnote</i>

Тэмдэглээ

*	авиан зүйн сэргээсэн хэлбэр
*...	авиан зүйн хувьд тайлагдаагүй байгаа үг, бүтээвэр
< >	үсэглэврийн филологийн галиг
<АБВ>	авиан зүйн хувьд тайлагдаагүй боловч утгын хувьд бүрэн тайлагдсан үг
.	үсэглэврийн хоорондох зааг
-	бүтээврийн зааг
ñ	тагнайн хамрын гийгүүлэгч
(?)	одоогоор бүрэн тайлагдаагүй, эргэлзээтэй утга
[123]	хятан үсгийн стандартчилсан дугаар (Шимүнек, 2017:423-444)
V	тодорхойгүй эгшиг

Abstract

(On the Origin of the Mongolian Toponym Khulj)

Keywords: *Mongolia in the Kitan Empire – onomastics - toponyms – historical-comparative linguistics – Kitan Empire (907-1125) – Kitan language – Khentii province – Bulgan province – Dundgow’ (Dundgov’ ~ Middle Gobi) province – 阿保機 Abaoji – 安巴堅 Anbajian – Ordu Baliq – Liao Annals (遼史 Liao Shi)*

This brief article proposes a Kitan etymology for the Mongolian toponym Khulj (Written Mongol *Qulji*), a word found in several place names, especially hydronyms, primarily near localities in Khentii province, Bulgan province, and Dundgow’ province known from archeological and inscriptional records to have had Kitan populations. We also briefly discuss the *Liao Annals* (in Chinese, 遼史 *Liao Shi*) account of the Kitan Emperor 阿保機 Abaoji or 安巴堅 Anbajian’s 924 A.D. capture of the then-ruined former Uyghur capital Ordu Baliq (known in Mongolian as Khar Balgas) in what is now modern Mongolia and the still-lost trilingual Kitan-Turkic-Chinese inscription mentioned in connection with this historical event.

Ном зүй

- Балжинням Б.** *Дэлхийн монголчуудын түүх*. Гутгаар дэвтэр. (НТ II-XIII зуун). Уб., 2012.
- Беквит** = Beckwith, Christopher I. *Empires of the Silk Road: A History of Central Eurasia from the Bronze Age to the Present*. Princeton: Princeton University Press. 2009.
- Виттфогел ба Фэн** = Wittfogel, Karl A. & Feng Chia-Sheng. *History of Chinese Society: Liao (907-1125)*. Transactions of the American Philosophical Society, New Series, Vol. 36. Philadelphia: American Philosophical Society. 1946.
- Домог.** Монгол утга соёл-3. Уб. 2014.
- Кэйн, Дэниэл** = Kane, Daniel 2013. The Great Central Liao Kitan State. *Journal of Song-Yuan Studies* 43: 27-50.
- Кэйн, Дэниэл** = Kane, Daniel 2009. *The Kitan Language and Script*. Handbook of Oriental Studies (Handbuch der Orientalistik), Section Eight: Central Asia, Vol. 19. Leiden: Brill.
- Пэрлээ Х.** *Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь*. Studia Historica. T-I, fasc. 1. Уб. 1959a.
- Пэрлээ Х.** *Чинтолгойн балгасны бичигт ваар*. Studia Mongolica. T-I, fasc. 5. Уб., 1959b.
- Пэрлээ Х.** *Киданчуудын бичгийн дурсгал монголоос олдсон нь*. Хэл зохиол судлал. T-13. Уб. 1978, х.15-30.
- Тогтоо** = 脱脱. 遼史. 中華書局. [Тото. Ляо Ши. Бээжин, Чжунхуа шуцзюй]. 1974.
- Хар Дорж** = Kara, György. *Хятан бичгийн хоёр тогтолцооны тухай*. Олон улсын монголч эрдэмтний III их хурал. Уб., 1977, х.86-89.
- Хар Дорж** = Kara, György. *On the Khitan writing systems*. Mongolian Studies-10: 1987, pp. 12-24.
- Хар Дорж** = Kara, György. *Books of the Mongolian Nomads: More than Eight Centuries of Writing Mongolian*. (translated to English by John R. Krueger). Bloomington, Indiana University. 2005.
- Чадраа Б.** (эрхлэн туурвисан) *Монголын үндэсний нэвтэрхий толь*. Боть-I. А-З. Боть-II. И-С. Боть-III. Т-Я. Уб., 2009.
- Чингэлтэй** = 清格爾泰. 契丹小字釋讀問題. 国立亞非語言文化研究所 [Цингээртай. Цидань сяоцзы шииду вэньти. Токио. Голи Я Фэй юйянь вэньхуа яньцзюсо]. 2002.
- Шагдар Ш.** *Монголын газарзүйн нэрийн товч толь бичиг*. 8000 орчим нэртэй. Нэмж засварласан 3-р хэвлэл. Уб., 2000.
- Шимүнек, Андрей** = Shimunek, Andrew. Review of The Kitan Language and Script by Daniel Kane. *Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae*. T-64 (1), Budapest, 2011, pp. 101-111.
- Шимүнек, Андрей** = Shimunek, Andrew. *Languages of Ancient Southern Mongolia and North China*. Tunguso-Sibirica. Band 40. Wiesbaden. Harrassowitz Verlag. 2017.